

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Э.АЛДАРБАЯР

**СУМЫН ТӨВИЙН ГЭР ХОРООЛЛЫН ГУДАМЖ БОЛОН НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙ, ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ХӨВӨӨ БОЛОН
ҮЕРИЙН УСНЫ ГАРГАЛГАА, ГАЗРЫН ГАДАРГЫГ ТЭГШИЛЖ ЯНЗЛАХ**

Техникийн үзүүлэлт	
Сумын төвийн хатуу хучилттай авто замын гарцуудад хучилт хийж тэгшлэх	<ul style="list-style-type: none">- 8600 метр хатуу хучилттай автозамын хөвөө болон уулзвар, гарцуудын эвдэрсэн хэсэгт шаварлаг шороог асгаж нягтруулах- Явган зам болон үндсэн замын бродур, явган замын хавтанг эвдэрсэн хэсгийг засварлах
Гэр хорооллын гудамж талбайн газрын гадаргууг тэгшлэх	Сумын төвийн гэр хорооллын Хөгшөө, Цохион ус, Шушаа хорооллын гудамж талбайн газрын гадаргад мэдэгдэхүйц хэмжээний хонхор, гүдгэр үүссэн хэсэг болон авто зам дагуух хонхорхой хэсгийг тэгшлэх, нягтруулах.
Үйлчилгээний төв болон орон сууцны орчмын газрын гадаргууг тэгшлэх.	Үйлчилгээний төв, орон сууцны хороолол дундах авто зам дагуу үүссэн хотгор гүдгэрийг тэгшлэх, нягтруулах
Дулаан, цэвэр усны шугам сүлжээ, бохир усны шугам сүлжээний дагуух ажил	2016 оноос хойш хийгдсэн цэвэр бохир усны шугам сүлжээ, дулааны шугам сүлжээний дагуух газрын гадрагад орсон өөрчлөлт буюу хотгор гүдгэр дээр дэвсэлт хийж тэгшилж нягтруулах. Нийт урт 10000 метр.
8.6 км замын үерийн гаргалгааны ажил	8.6 км хатуу хучилттай автозамын үерийн гаргалгаа буюу суваг суудууг цэвэрлэх үерийн ус чөлөөтэй урсаж байхаар янзлах.

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН БАЙЦААГЧ

А.АТАР

**СУМЫН ТӨВИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ХӨВӨӨ БОЛОН
ҮЕРИЙН УСНЫ ГАРГАЛГАА, ГЭР ХОРООЛЛЫН ГУДАМЖ БОЛОН НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД ГАЗРЫН ГАДАРГЫГ ТЭГШИЛЖ ЯНЗЛАХ**

2024 оны 06 сарын 04

Ажлын зорилго: Гурвантэс сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрийн "Цэгцтэй гэр хороолол" хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайг тэгшлэх, хатуу хучилттай авто замын хөвөө болон уулзвар, үерийн усны суваг шуудууг сэргээх, иргэдийг аюулгүй, тээврийн хэрэгслийг чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлэхэд оршино.

Ажлын технологийн үндсэн шаардлага:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зам, талбайн засвар, арчилгаа хийх ажлыг гүйцэтгэхдээ Байгаль орчныг хамгаалах хууль, Авто замын тухай хууль, бусад хуулиуд, БНБД-д заасан норм дүрмийн дагуу захиалагч, ашиглагчийн шаардлагад нийцүүлэн хавсралтад заасан техник угсралтын ажлын даалгаврын дагуу ажиллах шаардлагатай.

Дараах нөхцөлүүдэд гүйцэтгэгч анхаарч ажиллана.

- Ажлын үе шат бүрд фото зураг авч баталгаажуулах
- Техникийн болон ажлын акт, тайланг бүрдүүлэх

Гүйцэтгэгч нь : Дараах шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллана

- Гүйцэтгэсэн ажлыг акт, схем, фото зургаар баталгаажуулж, захиалагчид тухай бүр мэдэгдэж ажиллана.
- Гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэвтрийг өдөр тутам хөтөлж талбайн инженерийн гарын үсгээр баталгаажуулж ажиллана.
- Дээрх техникийн тодорхойлолтын шаардлагыг биелүүлээгүй, зам талбайг захиалагчийн шаардлагад нийцэхгүй байгаа тохиолдолд захиалагч байгууллага гэрээ цуцлах, санхүүжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.